БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Н.БАРМИД

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ХУДГИЙН ЦООНОГ ГАРГАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025.04.29 Алтан овоо

1	Ажил гүйцэтгэл	Цэнхэр сумын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ИТХ-ын 05 дугаар тогтоолд тусгагдсан
2	Захиалагч:	Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГазар
3	Байршил	Цэнхэр сумын Цэцэрлэг багийн Чулуут, Буйлан багийн Салхитын баянөндөр /2 байршилд 2 худгийн цооног/
3	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох, шавхалт	➢ Цооногийг зөвхөн баталгаатай гүний усны үеүдээс ус авах нөхөөлтэйгээр гаргах бөгөөд гадаргын болон түр үуурын хөрсний усны давхаргыг ашиглахгүй байх ➢ Цооногийн ашиглалтын ундарга: 2м3/цаг 6м3/цаг ус өгөх хүчин чадалтай байна. ➢ Суултын яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын гэрчилгээтэй байна. ➢ Шүүрийн яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын гэрчилгээтэй байна. ➢ Цооногоос ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/ ➢ Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна. ➢ Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй ➢ Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй

		➢ Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох ➢ Цохилтод өрмөөр өрөмдсөн тохиолдолд цооногийн нийт гүнд хамгаалалтын хуванцар хоолой хийнэ.
4	Мал услах онгоц, талбай барих	- Худгийн байшингүй - Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 50мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай, худгийн шалнаас 60 см-ийн өндөрт гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргана. - Ундны ус авах хоолой нь: 50 мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргасан /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/ байна. - 40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.
5	Мал услах онгоц	• Хэмжээ: 9м-ээс багагүй урттай байна. • Материал 400 мм-ийн голчтой, 1.5 мм-ийн зузаантай төмрөөр хагас цилиндр хэлбэртэй эсвэл цутгамал төмөр бетон /онгоцны дээд ирмэг газраас 50 см өндөр байна/ • Мал услах онгоцны доод хэсэг газраас 20 см байна. • Онгоцыг худгийн барилгаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эргэдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулан гагнана. Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.
6	Худгийн ус шахуурга, ус өргөх хоолой, шүүр	• Худгийн ус шахуурга: ISO9001:2015 стандартын шаардлага хангасан байх

	яндан, цахилгаан үүсгүүр	• Ус шахуургын хөдөлгүүр нь олон улсын EN60335-1, 2012+A11 2014,AC:2014 стандартын шаардлага хангасан, 3 салаа цахилгааны утастай, утас нь ус шахуургын удирдлагын самбараар дамжин цахилгаанд холбогдоно. • Ус шахуурга нь 2019 онд үйлдвэрлэгдсэн байх/гарал үүслийн гэрчилгээ хавсаргах/ • Цахилгааны утас: IEC 60227-5 болон ISO 9001:2015 чанарын стандартын шаардлага хангасан. • VCTF эсвэл түүнтэй дүйцэхүйц загварын 3 салаатай, ус чийгнээс хамгаалагдсан давхар бүрээстэй, цооногт устай нөхцөлд ашиглах шаардлагыг хангасан байх, утас нь ус шахуургаас хянах самбар хүртэл залгаасгүй үргэлжилсэн байх. • Ус өргөх хоолой: • GB/T18997:1-2002 стандартын шаардлага хангасан, зориулалтын түүхий эдээр хийгдсэн, доод тал нь 1.0 МПас-с багагүй даралт даах чадвартай, цагаан өнгийн, дотор давхарга нь тунгалаг, ундны ус дамжуулах зориулалттай байх, Хоолойн гадна диаметр 32 мм-с багагүй байна. • Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, ус шахуурга ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах дохиололтой, цахилгаан үүсгүүр ажиллуулах асаагууртай. • Худгийн шүүр яндан: 100 м хүртэл гүнтэй цооног дахь шүүрийн яндангийн гадаад диаметр нь 127 мм-ээс доош байна. • Хуванцар хоолой нь анхдагч түүхий эд ашиглаж үйлдвэрлэсэн, MNS5544:2007 чанарын шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй байх, ундны усны стандартын шаардлага хангасан, лабораторийн шинжилгээтэй байна. • Эргэлтэт, цохилтот өрөмдлөгийн аргаар

		өрөмдсөн цооногт дахь шүүрийн янданд ус нэвтрүүлэх шүүрийг зориулалтын төхөөрөмжөөр хөндлөн байрлалаар нэг эгнээнд 8-10 ширхэг, 40-80 мм хэмжээтэй цуулбарлан ашиглаж болно. Хоолойн зузаан нь 3 мм-ээс багагүй байна. • Цахилгаан үүсгүүр: Бензинээр ажилладаг, 220 V гаргадаг мотор /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх
7	Нэмэлт	Аймгийн Байгаль орчны газраас газрын хэвлий хөндөх зөвшөөрөл авах
	Санхүүжилт	40,000,000
8	Дээрхи ажлыг гүйцэтгэх хугацаа	2024..... – 2024 .....

ХЯНАСАН:
ЗДТГ-ЫН ДАРГА Э.БОЛОРЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН
ХААТ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Ч.ОЛОНБАЯР